



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Биеийн тамир спортын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/133/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг, Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 99092469	Цахим хаяг:
Аудитын менежер:	Э.ЭНхцэцэг
Утас: 90077079	Цахим хаяг:
Аудитор:	Г.Энхтөр
Утас: 96441690	Цахим хаяг:

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	10
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайвиганд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34	ДОРНОГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Г.БАТЛХАМ ТАНАА
2019.02.26 № 1-4/212	
тантай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Биеийн тамир спортын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Г.Батлхамд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.12-наас 2019.02.13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.22-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар нь Нийгмийн эрүүл мэнд , нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх , иргэдийн биеийн тамирч , спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх , оюун санаа бие бялдрын хөгжлийг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэнд , нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн программ” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой юм.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны нийт зардал 394,510.00 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 789.02 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	23.30	
3	Албан шаардлага өгсөн	1	29.267.40	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	29.290.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Дасгалжуулагч Б.Сумьяад Нийгмийн даатгалын сангаас 2 хоног буюу 23293 төгрөгийн ХЧТА-ны тэтгэмж давхар бодож олгосон байна.

Эрсдэл:

Энэ нь санхүүгийн тайлан үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагаатай хүрээнд бий болсон усан бассейны орлого 29,267.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Эрсдэл:

Энэ нь санхүүгийн тайлан үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 216 тоот тушаалаар баталсан журмыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

НББББ-ийн улам боловсронгуй болгож хөрөнгийн бүртгэлийг тодорхой зааж өгөх

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой арга хэмжээнд зориулан 2018 онд 306,127.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 307,684.5 мянган төгрөг буюу 100,5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны орлогоос зардлыг санхүүжүүлснээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>89,314,811.11</u>	<u>87,867,622.26</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	30.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	30.00
3121	Төгрөг	00.00	30.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	30.00
33	АВЛАГА	6,480,880.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	410,000.00	00.00
335	Бусад авлага	6,070,880.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	6,070,880.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,833,931.11	87,867,592.26
354	Хангамжийн материал	82,833,931.11	87,867,592.26
35410	Бичиг хэргийн материал	2,902,900.00	340,800.00
35420	Аж ахуйн материал	78,931,031.11	86,466,792.26
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	1,060,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>745,518,121.91</u>	<u>1,781,107,509.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	745,518,121.91	1,781,107,509.01
392	Биет хөрөнгө	745,447,538.70	851,347,509.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,240,150,470.00	902,029,606.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-527,697,421.29	-114,036,592.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,364,710.81	71,486,992.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,763,998.24	-29,447,023.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,752,753.54	65,098,882.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,364,976.12	-43,790,356.66
39217	Ном	6,000.00	6,000.00
393	Биет бус хөрөнгө	70,583.21	929,760,000.00
39301	Програм хангамж	785,000.00	785,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-714,416.79	-785,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	929,760,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>834,832,933.02</u>	<u>1,868,975,131.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>756,000.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	756,000.00	00.00
413	Өглөг	756,000.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	756,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>834,076,933.02</u>	<u>1,868,975,131.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	834,076,933.02	1,868,975,131.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	437,828,204.56	1,367,588,204.56
51101	Өмч: - төрийн	437,828,204.56	1,367,588,204.56
512	Хуримтлагдсан үр дүн	112,773,017.46	124,119,115.66
51210	Өмнөх үеийн үр дүн	112,773,017.46	139,716,159.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-15,597,043.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	283,475,711.00	377,267,811.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>834,832,933.02</u>	<u>1,868,975,131.27</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	396,782,250.00	378,911,104.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147,465,170.00	21,510,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	147,465,170.00	21,510,850.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	147,465,170.00	21,510,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,599,890.00	15,764,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,400,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	130,465,280.00	5,746,350.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,249,180.00	65,480,254.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	223,067,900.00	291,920,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,249,180.00	65,480,254.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,051,180.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,198,000.00	8,412,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	27,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	29,267,404.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	259,764,928.27	390,651,602.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259,764,928.27	390,651,602.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,376,964.27	371,624,662.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,816,454.00	119,101,621.00
210101	Үндсэн цалин	97,816,454.00	119,101,621.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,232,436.00	14,112,472.00
210201	Тэтгэврийн даатгал	6,116,567.00	9,559,235.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,266,496.00	1,186,201.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	946,547.00	948,957.00
210204	Ажилгүйдлийн даатгал	172,982.00	213,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,729,844.00	2,204,751.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,399,709.00	91,922,795.00
210301	Гэрэл, цахилгаан	2,035,929.00	3,103,357.00
210302	Түлш, халаалт	50,250,036.00	65,099,216.00
210303	Цэвэр, бохир ус	2,113,744.00	23,720,222.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,862,541.00	11,812,424.00
210401	Бичиг хэрэг	539,900.00	3,945,410.00
210402	Тээвэр, шатахуун	540,700.00	2,938,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	748,541.00	843,009.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,400.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	3,565,880.00
2105	Нормативт зардал	55,900.00	1,930,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	55,900.00	1,930,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,401,121.00	18,054,746.85
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	532,000.00
210602	Тавилга	00.00	1,246,916.85

Дорноговь амйгийн Биеийн тамир спортын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	5,401,121.00	16,275,830.00
2107	Томилолт, зочны зардал	286,600.00	995,500.00
210702	Дотоод албан томилолт	286,600.00	995,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	526,960.00	193,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	73,600.00	00.00
210807	Газрын төлбөр	166,400.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	286,960.00	193,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,795,243.27	113,500,853.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,827,076.00	60,156,262.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,968,167.27	53,344,591.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,387,964.00	19,026,940.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,600,000.00	486,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,600,000.00	486,150.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,787,964.00	18,540,790.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,787,964.00	18,540,790.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	137,017,321.73	-11,740,498.47
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	3,856,545.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	207,176.97
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	3,649,368.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-3,856,545.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	137,017,321.73	-15,597,043.80

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	263,552,040.00	376,215,934.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,286,140.00	18,815,680.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,286,140.00	18,815,680.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,286,140.00	15,764,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,886,140.00	15,764,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,400,000.00	00.00
120009	Бусад орлого	00.00	3,051,180.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	246,265,900.00	357,400,254.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	223,067,900.00	291,920,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,198,000.00	65,480,254.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,198,000.00	8,412,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	27,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	29,267,404.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	263,552,040.00	339,123,622.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	263,552,040.00	339,123,622.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,164,076.00	319,718,682.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,816,454.00	119,051,621.00
210101	Үндсэн цалин	97,816,454.00	119,051,621.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,232,436.00	14,508,472.00
210201	Тэтгэврийн даатгал	6,625,823.00	9,328,797.00
210202	Тэтгэмжийн даатгал	757,240.00	1,812,639.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	946,547.00	948,957.00
210204	Ажилгүйдлийн даатгал	172,982.00	213,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,729,844.00	2,204,751.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,277,913.00	89,134,095.00
210301	Гэрэл, цахилгаан	5,448,929.00	3,334,357.00
210302	Түлш, халаалт	52,500,003.00	62,079,516.00
210303	Цэвэр, бохир ус	5,328,981.00	23,720,222.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,353,916.00	8,931,072.00
210401	Бичиг хэрэг	3,249,500.00	1,360,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,372,700.00	2,998,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,195,816.00	843,009.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,400.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,502,500.00	3,209,938.00
2105	Нормативт зардал	55,900.00	2,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	55,900.00	2,000,000.00

Дорноговь амйгийн Биеийн тамир спортын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,467,261.00	23,966,310.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	8,659,000.00
210604	Урсгал засвар	7,467,261.00	15,307,310.00
2107	Томилолт, зочны зардал	335,100.00	995,500.00
210702	Дотоод албан томилолт	335,100.00	995,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	751,700.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	73,600.00	00.00
210807	Газрын төлбөр	166,400.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	511,700.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,873,396.00	61,131,612.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,873,396.00	61,131,612.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,387,964.00	19,404,940.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,600,000.00	864,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,600,000.00	864,150.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,787,964.00	18,540,790.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,787,964.00	18,540,790.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	37,092,312.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	37,092,282.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	37,092,282.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	37,092,282.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	37,092,282.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-37,092,282.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	30.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	30.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	437,828,204.56	285,768,229.00	63,184,690.82	786,781,124.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	171,778.00	171,778.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	437,828,204.56	285,768,229.00	63,356,468.82	786,952,902.38
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-34,606,468.23	-34,606,468.23
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	437,828,204.56	283,475,711.00	112,773,017.46	834,076,933.02
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	437,828,204.56	283,475,711.00	112,773,017.46	834,076,933.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	26,943,142.00	26,943,142.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	437,828,204.56	283,475,711.00	139,716,159.46	861,020,075.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	93,792,100.05	00.00	93,792,100.05
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	929,760,000.00	00.00	-15,597,043.80	914,162,956.20
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,367,588,204.56	377,267,811.05	124,119,115.66	1,868,975,131.27

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	306,127,500.00	307,684,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,127,500.00	307,684,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,127,500.00	299,853,710.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,052,000.00	119,051,621.00
210101	Үндсэн цалин	119,052,000.00	119,051,621.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,832,700.00	14,508,472.00
210201	Тэтгэврийн даатгал	14,188,500.00	9,328,797.00
210202	Тэтгэмжийн даатгал	728,800.00	1,812,639.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	911,100.00	948,957.00
210204	Ажилгүйдлийн даатгал	182,200.00	213,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,822,100.00	2,204,751.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,197,500.00	89,134,095.00
210301	Гэрэл, цахилгаан	5,587,900.00	3,334,357.00
210302	Түлш, халаалт	53,018,600.00	62,079,516.00
210303	Цэвэр, бохир ус	29,591,000.00	23,720,222.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,700,000.00	5,689,854.00
210401	Бичиг хэрэг	360,000.00	360,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,998,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000.00	843,009.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	968,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,137,800.00	39,267,310.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
210602	Тавилга	15,000,000.00	11,360,000.00
210604	Урсгал засвар	13,137,800.00	12,907,310.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	995,500.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	995,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31207500.00	31206858.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,207,500.00	31,206,858.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	306,127,500.00	307,684,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	291,920,000.00	291,920,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,920,000.00	291,920,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,207,500.00	15,764,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,207,500.00	15,764,500.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	22.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	10.00